

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2024 оны ... дугаар сарын ... -ны өдрийн
... дугаар албан бичгийн хавсралт



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**УЛААНБААТАР
ХОТ**

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангах болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, бодлого, төлөвлөлтийг сайжруулах, төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Арга зүй

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасны дагуу үндсэн 5 бүлэг, 18 зорилго, 75 төсөл, арга хэмжээ, 201 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1-т заасан аргачлалаар, төсөл, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг мөн журмын 6.2.2-т заасан аргачлалаар тус тус үнэлсэн.

Тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан www.unelgee.gov.mn/-гаар баталгаажуулан, хяналтад авч нэгтгэсэн бөгөөд 14 яам, 4 агентлаг, нийслэл тайланг хугацаандаа ирүүлсэн. Хэрэгжилтийг ЗТХЯ, ХХААХҮЯ, МБ, ОБЕГ хугацаа хоцроож ирүүлсэн. Төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлэгчээр батлагдсан 21 аймгийн Засаг даргын Тамгын газар хэрэгжилтийн тайланг цахим санд баталгаажуулан тайлагнахаас 19 аймгийн Засаг даргын Тамгын газар хугацаандаа тайлагнаж, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар хугацаа хоцроож тайлагнасан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

3.1. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого, Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн 5 бүлэг, 18 зорилго, 75 төсөл, арга хэмжээ тусгагдсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн дүнгээр дунджаар **79.2** хувьтай үнэлэгдлээ.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 75 төсөл, арга хэмжээнээс 16 төсөл, арга хэмжээ үр дүнтэй буюу “100.0” хувийн хэрэгжилттэй, 44 төсөл, арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу “70-99” хувийн хэрэгжилттэй, 12 төсөл, арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу “30-69” хувийн хэрэгжилттэй, 3 төсөл, арга хэмжээ, үр дүнгүй буюу “0-29” хувийн хэрэгжилттэй тус тус үнэлэгдлээ.


Төлөвлөгөөний биелэлтийг бодлого болон хэрэгжилтийн хувиар нэгтгэн харуулбал:

Хүснэгт 1. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт (бодлого, хэрэгжилтийн хувиар)

№	Бодлого	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)						Дундаж хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
			Үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн	эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй			
1	Хүний хөгжлийн бодлого	23	8	4	7	1	-	3	76.2
2	Эдийн засгийн бодлого	24	4	5	6	6	3	-	76.1
3	Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого	11	2	7	2	-	-	-	92.0
4	Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого	8	1	3	2	1	1	-	79.1
5	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	9	1	2	6	-	-	-	82.0
Нийт		75	16	21	23	8	4	3	79.2
Нийт дүнд эзлэх хувь		100.0	21.3	28.0	30.6	10.7	5.3	4.0	

Төлөвлөгөөнд тусгагдсан бодлого тус бүрийн хэрэгжилтийг харьцуулан авч үзэхэд Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого 92.0 хувь, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого 82.0 хувьтай хэрэгжсэн байгаа нь бусад бодлоготой харьцуулахад хэрэгжилт 10.0-15.9 хувиар илүү байна.

График 1. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үндсэн 5 бодлогоор



3.1.1.Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүний хөгжлийн бодлогын 6 зорилгын хүрээнд 23 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 76.2 хувь буюу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Зорилго тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх хүрээнд 8 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 88.7 хувьтай, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 96.7 хувьтай, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 43.9 хувьтай, хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд 3 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 53.3 хувьтай, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувьтай, үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд 1 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 82.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Хүний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгын үнэлгээ

№	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)						Дундаж хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
			Үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн		эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
1	Зорилго 1.1.Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	8	4	1	2	1	-	-	88.7
2	Зорилго 1.2.Судалгаа хөгжүүлэлт, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлнэ.	2	1	1	-	-	-	-	96.7
3	Зорилго 1.3.Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	4	-	-	2	-	-	2	43.9
4	Зорилго 1.4.Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, амралт, чөлөөт цагаа зөв боловсон	3	-	1	1	-	-	1	53.3

	өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.								
5	Зорилго.1.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ.	5	3	1	1	-	-	-	92.0
6	Зорилго 1.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1	-	-	1	-	-	-	82.5
Нийт		23	8	4	7	1	-	3	76.2

3.1.2. Эдийн засгийн бодлогын хүрээнд:

Эдийн засгийн бодлогын 6 зорилгын хүрээнд 24 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 76.1 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Зорилго тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, өрийн менежментийг сайжруулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах хүрээнд 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 100.0 хувьтай, боомтын сэргэлтийг эрчимжүүлэх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэн эдийн засгийн өсөлтийг тэтгэж, экспортыг нэмэгдүүлэх хүрээнд 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 71.5 хувьтай, эрчим хүчний сэргэлтийг эрчимжүүлэх найдвартай, тогтвортой эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг шинээр барьж байгуулах хүрээнд 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 69.8 хувьтай, аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 64.5 хувьтай, хөдөө аж ахуйн гол нэрийн 19 бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 73.8 хувьтай, байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд 4 төсөл, арга хэмжээний биелэлт 76.8 хувьтай байна.

Хүснэгт 3. “Эдийн засгийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгын үнэлгээ

№	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)						Дундаж хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
			Үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн	эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй			
1	Зорилго 2.1.Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, өрийн	4	4	-	-	-	-	-	100

	менежментийг сайжруулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангана.								
2	Зорилго 2.2.Боомтын сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэн эдийн засгийн өсөлтийг тэтгэж, экспортыг нэмэгдүүлнэ.	2	-	-	1	1	-	-	71.5
3	Зорилго 2.3.Эрчим хүчний сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд эрчим хүчний найдвартай, тогтвортой эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг шинээр барьж байгуулна.	4	-	-	2	2	-	-	69.8
4	Зорилго 2.4.Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.	5	-	1	1	3	-	-	64.5
5	Зорилго 2.5.Хөдөө аж ахуйн гол нэрийн 19 бүтээгдэ-хүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	5	-	2	2	-	1	-	73.8
6	Зорилго 2.6.Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	4	-	2	-	-	2	-	76.8
Нийт		24	4	5	6	6	3	-	76.1

3.1.3.Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлогын хүрээнд:

Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлогын 3 зорилгын хүрээнд 11 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 92.0 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Зорилго тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 97.7 хувьтай, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангах хүрээнд 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 88.3 хувьтай, Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан, мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хүрээнд 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Хүснэгт 4. Засаглалын бодлогыг хэрэгжүүлэх зорилгын үнэлгээ

№	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)						Дундаж хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
			Үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн		эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
1	Зорилго 3.1.Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлнэ.	5	2	3	-	-	-	-	97.7
2	Зорилго 3.2. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана	4	-	2	2	-	-	-	88.3
3	Зорилго 3.3.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан, мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ	2	-	2	-	-	-	-	90.0
Нийт		11	2	7	2	-	-	-	92.0

3.1.4 Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлогын хүрээнд:

Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 8 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 79.1 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 5. “Ногоон хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгын үнэлгээ

№	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)						Дундаж хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
			Үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн		эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
1	Зорилго 3.1.Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн	8	11	1	3	2	1	-	79.1

нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлнэ.								
Нийт	8	11	1	3	2	1	-	79.1

3.1.5 Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын 2 зорилгын хүрээнд 9 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 82.0 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Зорилго тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, хот, хөдөөгийн сэргэлтийг эрчимжүүлэх, Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, амьдрах таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх хүрээнд 6 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 88.2 хувьтай, бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх хүрээнд 3 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 75.8 хувьтай байна.

Хүснэгт 6. “Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгын үнэлгээ

№	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)					Дундаж хувь	
			100.0	90.0	70.0	50.0	30.0		0.0
			Үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн		эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
1	Зорилго 5.1.Хот, хөдөөгийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, амьдрах таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.	6	1	2	3	-	-	-	88.2
	Зорилго 5.2.Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	3	-	-	3	-	-	-	75.8
Нийт		9	1	2	6	-	-	-	82.0

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан байгууллагаар авч үзвэл Санхүүгийн зохицуулах хороо 100.0 хувь, Авлигатай тэмцэх газар 100.0 хувь, Эдийн засаг, хөгжлийн яам 97.5 хувь, Монголбанк 96.7, Сангийн яам 95.0 хувийн хэрэгжилттэй байгаа нь бусад яам, агентлагаас илүү гүйцэтгэл өндөр хувьтай байна.

Хүснэгт 7. Үнэлгээ яамд, байгууллагаар

№	Байгууллага	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)						Дундаж хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
			Үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн		эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
1	БОАЖЯ	9	1	3	2	1	2		70.3
2	БХБЯ	7	1	2	4				82.9
3	БХЯ	2		2					90.0
4	БШУЯ	12	4	3	3	2			85.3
5	ГХЯ	2	1	1					95.0
6	ЗТХЯ	4			2	1	1		60.5
7	СЯ	5	3	1	1				95.0
8	СоЯ	2		1	1				84.8
9	УУХҮЯ	5		2		3			73.5
10	ХНХЯ	6	2	3				1	79.4
11	ХЗДХЯ	6	1	4	1				90.0
12	ХХААХҮЯ	6	1	2	2		1		77.7
13	ЦХХХЯ	1		1					90.0
14	ШС	1			1				70.0
15	ЭЗХЯ	4	3	1					97.5
16	ЭМЯ	4			2			2	43.5
17	ЭХЯ	4			2	2			68.3
18	БТСУХ	1			1				70.0
19	МБ	2	1	1					96.7
20	СЗХ	1	1						100.0
21	НЗДТГ	4	1	1	2				87.5
22	АТГ	1	1						100.0

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн дүнгээр “100” хувийн хэрэгжилттэй буюу үр дүнтэй үнэлэгдсэн дараах 16 төсөл, арга хэмжээ байгаа ба энэ нь БШУЯ /5/, СЯ /2/, ЭЗХЯ /1/, МБ /3/, ХНХЯ /1/, БОАЖЯ /1/, ХХААЯ /1/, БХБЯ /1/, АТГ /1/ тус тус хариуцсан төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

[1.1.1] Багшийн ур чадварыг сайжруулж, үнэлэмжийг дээшлүүлэх “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх /Арга хэмжээний хэрэгжилт, хувиар/;

[1.1.3] Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, монгол хүний хандлага, хүмүүжил, төлөвшилд нийцсэн түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны агуулгаар баяжуулсан сургалтын хөтөлбөр боловсруулах /Арга хэмжээний хэрэгжилт, хувиар/;

[1.1.5] Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах /Ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн тоо/

[1.1.8] Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч, багш мэргэжлээр суралцагчид сурлагын амжилттай нь уялдуулан тэтгэлэг олгох /Арга хэмжээний хэрэгжилт, хувиар/

[1.2.1] Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгааны ажлыг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэх /Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардал, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар/

[1.5.3] Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхлэгчдэд ажлын байр бий болгох, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх /Дэмжлэгт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхлэгчдийн тоо/

[1.5.4] Үндэсний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх, чадавхжуулах “Үндэсний ханган нийлүүлэлт” арга хэмжээг хэрэгжүүлэх /Арга хэмжээний хэрэгжилт, хувиар/

[1.5.5] Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох /Арга хэмжээний хэрэгжилт, хувиар/

[2.1.1] Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах мөнгөний бодлого хэрэгжүүлэх /Инфляцын түвшин, хувиар/

[2.1.2] Засгийн газрын өрийн хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаараас хэтрүүлэхгүй байхад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх /Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэх Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь/

[2.1.3] Санхүүгийн зах зээлийг өргөжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх /Арга хэмжээний хэрэгжилт, хувиар/

[2.1.4] Тогтвортой санхүүжилт болон ногоон төслүүдийг дэмжих тогтолцоог бүрдүүлж, хөгжлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх /Арга хэмжээний хэрэгжилт, хувиар/

[3.1.1] Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх /Татварын тайлагналт, хураалтыг цахимжуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар/

[3.1.3] Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах /Арга хэмжээний хэрэгжилт, хувиар/

[4.1.5] Хүн амын унд, ахуйн ус хангамжийн нөөц тогтоох хайгуул судалгаа хийх /Нөөц тогтоох сумын төвийн тоо/

[5.1.2] Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах /Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэдийн тоо/

Харин “0.0” хувийн хэрэгжилттэй буюу үр дүнгүй үнэлэгдсэн дараах 2 төсөл, арга хэмжээ байгаа ба энэ нь ЭМЯ /1/, ХНХЯ /1/ тус тус хариуцсан арга хэмжээ байна. Үүнд:

[1.3.2] Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэх /Ариун цэврийн байгууламжийг шинэчлэх сумын эрүүл мэндийн төвийн тоо/;

[1.4.2] Хүүхдийн хөгжлийг дэмжих “Найрамдал-2” зуслангийн цогцолбор барих /Барилгын ажлын явц, хувиар/;

Эдгээр төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй шалтгааныг авч үзвэл, санхүүжилт, хөрөнгө оруулалт шийдэгдээгүй /2/ арга хэмжээ байна.

3.2. Санхүүжилтийн гүйцэтгэл

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд 75 төсөл, арга хэмжээ, 201 шалгуур үзүүлэлтийг 15,137.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 9,839.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн нь нийт төлөвлөсөн дүнгийн 65.0 хувийг эзэлж байна.

Нийт 75 төсөл, арга хэмжээнээс санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхойлсон боловч мөнгөн дүнг төлөвлөгөөнд тусгаагүй улсын төсвөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн 19 төсөл, арга хэмжээ байна. Харин нийт 75 төсөл, арга хэмжээнээс гүйцэтгэлээр 57 төсөл, арга хэмжээ 2023 оны жилийн эцсийн санхүүжилт авсан бөгөөд үүнээс батлагдсан төлөвлөгөөнд мөнгөн дүнг тусгаагүй 22 төсөл, арга хэмжээнд 2,048.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хувьд зарим төсөл, арга хэмжээ нь хэд хэдэн шалгуур үзүүлэлтээс бүрдэж байгаа бөгөөд шалгуур үзүүлэлт

бүр ялгаатай санхүүжилтийн эх үүсвэртэй байх тул санхүүжилтийн гүйцэтгэлийг 201 шалгуур үзүүлэлтийн хувьд авч үзлээ.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 129 шалгуур үзүүлэлтэд 1,887.7 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 88 шалгуур үзүүлэлтэд (үүний 9 шалгуур үзүүлэлтэд 85.1 тэрбум төгрөгийг Засгийн газрын тусгай сангаас) 2,427.4 тэрбум төгрөг;
- Гадаадын зээл, тусламжаар 26 шалгуур үзүүлэлтэд 1,646.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 25 шалгуур үзүүлэлтэд 1,049.9 тэрбум төгрөг;
- Гадаадын хөрөнгө оруулалтаар 4 шалгуур үзүүлэлтэд 3,004.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4 шалгуур үзүүлэлтэд 2,730.4 тэрбум төгрөг;
- Төр-хувийн хэвшлийн түншлэлээр 22 шалгуур үзүүлэлтэд 4,197.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл гараагүй буюу 0 төгрөг;
- Орон нутгийн төсвөөр 4 шалгуур үзүүлэлтэд 420.0 тэрбум төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 6 шалгуур үзүүлэлтэд 129.8 тэрбум төгрөг;
- Дотоодын хөрөнгө оруулалтаар 10 шалгуур үзүүлэлтэд 1,786.0 тэрбум төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 9 шалгуур үзүүлэлтэд 1,973.2 тэрбум төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банкаар 2 шалгуур үзүүлэлтэд 51.5 тэрбум төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 2 шалгуур үзүүлэлтэд 83.5 тэрбум төгрөг;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 5 шалгуур үзүүлэлтэд 1,243.4 тэрбум төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 2 шалгуур үзүүлэлтэд 1,443.8 тэрбум төгрөг;
- Бусад буюу Монголбанк, арилжааны банк 1 шалгуур үзүүлэлтэд 900.0 тэрбум төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 2 шалгуур үзүүлэлтэд 926.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 8. Шалгуур үзүүлэлтийн санхүүжилтийн эх үүсвэр

дд	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөсөн		Гүйцэтгэл	
		Шалгуур үзүүлэлт	сая төгрөг	Шалгуур үзүүлэлт	сая төгрөг
1	Улсын төсөв	129*	1,887,663.7	88*	2,427,423.7
2	Гадаадын зээл, тусламж	26	1,646,452.9	25*	1,049,987.6
3	Гадаадын хөрөнгө оруулалт	4*	3,004,814.0	4*	2,730,410.8
4	Төр-хувийн хэвшлийн түншлэл	22	4,197,236.7	-	-
5	Орон нутгийн төсөв	4*	420,000.0	6*	129,843.4
6	Дотоодын хөрөнгө оруулалт	10*	1,786,004.9	9*	1,973,165.0
7	Монгол Улсын Хөгжлийн банк	2	51,458.0	2	83,454.0
8	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	5	1,243,377.5	2	1,443,800.8
9	Бусад	1	900,000.0	2*	926.0
Нийт		201	15,137,007.7	138	9,839,011.4

*Дээрх хүснэгтэд тэмдэглэсэн тоонуудын хувьд зарим нэг шалгуур үзүүлэлтүүд нь 2, 3 санхүүжилтийн эх үүсвэртэй байх тохиолдол гарсан тул ялгаж харууллаа. Жишээлбэл, 2.4.1.7 дахь шалгуур үзүүлэлт гадаадын хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулалт гэсэн 2 төрлийн санхүүжилтийн эх үүсвэртэй байхаар "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-нд тусгагдаж батлагдсан.

Төлөвлөгөөнд тусгагдсан 201 шалгуур үзүүлэлтэд 9 төрлийн эх үүсвэрээс 15,137.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төлөвлөснөөс 138 шалгуур үзүүлэлт 9,839.0 тэрбум төгрөгөөр санхүүжсэн байна. Нийт санхүүжилтийн 27.8 хувь буюу 4 шалгуур үзүүлэлтийг гадаадын хөрөнгө оруулалтаар (УУХҮЯ төлөвлөсөн бүх санхүүжилтийг бүрэн зарцуулсан гэж тайлагнасан нь өндөр хувийг эзэлсэн), 24.7

хувь буюу 88 шалгуур үзүүлэлтийг улсын төсвөөр, 20.1 хувь буюу 9 шалгуур үзүүлэлтийг дотоодын хөрөнгө оруулалтаар, 14.7 хувь буюу 2 шалгуур үзүүлэлтийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар, 10.7 хувь буюу 25 шалгуур үзүүлэлтийг гадаадын зээл, тусламжаар, 1.3 хувь буюу 6 шалгуур үзүүлэлтийг орон нутгийн төсвөөр, 0.8 хувь буюу 2 шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын Хөгжлийн банкаар тус тус санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд 201 шалгуур үзүүлэлт бүрээр эх үүсвэрийг төлөвлөсөн хэдий ч зарим шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлээс үзэхэд 17 шалгуур үзүүлэлтийн санхүүжилтийн эх үүсвэр төлөвлөснөөс өөрчлөгдсөн нь улсын төсөвт хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжилт хийгдсэн зэрэгтэй холбоотой байгаа бол 10 шалгуур үзүүлэлтийн санхүүжилт төлөвлөснөөс өндөр гүйцэтгэлтэй гарсан байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувьд яамд, холбогдох байгууллагууд цахим системд тайлагнахдаа гадаад валютаар мөнгөн дүнг илэрхийлэх, сая төгрөгөөр илэрхийлэхээр заасан байхад тэрбум төгрөг, мянган төгрөг гэх мэтээр оронгийн нарийвчлалгүй буруу тайлагнах, эх үүсвэрийг дурдаагүй байх, өмнөх 2022 оны зардлыг 2023 оны зардалтай нэгтгэж өссөн дүнгээр тайлагнах зэрэг алдаатай мэдээллийг тайлагнасан тул бүх яамдын уг тайланг хариуцсан албан хаагч нарт жишиг хүснэгт боловсруулан хүргүүлж, албаны цахим шуудангаар мэдээллийг дахин баталгаажуулж авсан. Ирүүлсэн санхүүжилтийн гүйцэтгэлийг хянахад үндсэн болон хамтран хариуцагчийн гүйцэтгэл ялгаатай байхаас эхлээд өмнөх алдаатай мэдээллийг залруулаагүй тул дахин хянаж ажилласан.

Аймгуудын Засаг даргын Тамгын газар /ЗДТГ/-ын цахим системд тайлагнасан мэдээллүүдээс үзэхэд, дийлэнх аймгийн ЗДТГ санхүүжилтийн гүйцэтгэлийн хэсгийг тайлагнаагүй байх бөгөөд санхүүгийн гүйцэтгэлийн хэрэгжилт тайлагнасан аймгийн ЗДТГ-ын хувьд санхүүжилтийн гүйцэтгэлийг нэгтгэхэд өмнөх оны санхүүжилтийн гүйцэтгэлийг 2023 оны санхүүжилтийн гүйцэтгэлтэй хамт өссөн дүнгээр тайлагнасан, үндсэн хариуцагчийн хэрэгжилтэд тусгагдсан гүйцэтгэлийн хэмжээг давхар ирүүлсэн, үндсэн хариуцагчийн гүйцэтгэлээс хэт өндөр дүнтэй, хэрэгжилттэй нийцээгүй гүйцэтгэлийн мэдээлэл тайлагнасан зэрэг нийтлэг алдаа дутагдал байсан тул аймгуудын ЗДТГ-аас ирүүлсэн санхүүжилтийн гүйцэтгэлтэй холбогдох мэдээллийг үндсэн хариуцагчийн мэдээлэлд тусгагдсан гэж үзсэн.


Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд 5 бүлэг, 18 зорилго бүхий нийт 75 төсөл, арга хэмжээ, 201 шалгуур үзүүлэлт тусгагдсанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 79.2 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн бөгөөд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол, нийт батлагдсан төсөл, арга хэмжээний 21.3 хувь буюу 16 төсөл, арга хэмжээ “үр дүнтэй”, 58.7 хувь буюу 44 төсөл, арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 12.0 хувь буюу 9 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 8.0 хувь буюу 6 төсөл, арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдлээ.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд 75 төсөл, арга хэмжээг 15.1 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 9.8 их наяд төгрөгийг зарцуулсан нь нийт төсөвлөсөн дүнгийн 65.0 хувийг эзэлж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан байгууллагаар авч үзвэл Санхүүгийн зохицуулах хороо 100.0 хувь, Авлигатай тэмцэх газар 100.0 хувь, Эдийн засаг, хөгжлийн яам 97.5 хувь, Монголбанк 96.7 хувь, Сангийн яам 95.0 хувийн хэрэгжилттэй байгаа нь бусад яам, агентлагаас илүү гүйцэтгэл өндөр байна.

График 2. “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт, яамд, байгууллагаар



Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө нь суурь болон зорилтот түвшин бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлттэй батлагдсан бөгөөд тайлан ирүүлсэн байгууллагууд журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалыг ашигласан байна.

Тав. Санал

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Төлөвлөлтийг сайжруулах талаар:

1. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээг боловсруулахдаа тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн болон хамтран хариуцагч байгууллагуудын оролцоог чиг үүргийн дагуу нарийвчлан тооцож тусгах;

2. Төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт бүрд нэг байгууллагыг үндсэн хариуцагчаар төлөвлөж, бусад хамтран хариуцагч байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, эргэх уялдаа холбоог сайжруулах.

Тайлагналыг сайжруулах талаар:

1. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn мэдээллийн цахим санд тайланг оруулахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх

үүсвэрийг тодорхой тусгаж, нотлох баримтыг хавсарган, иж бүрэн тайлагнах, мөн хагас жилийн болон жилийн эцсийн тайланд санхүүжилтийн гүйцэтгэлийг оруулахдаа дүнг сайтар нягталж, зарцуулалтыг бүрэн гүйцэд тайлагнаж байх;

2.Бодлогын баримт бичигт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжилтийг тайлагнах;

3.Тайлангийн үг, үсэг, утга найруулгын алдаанаас гадна санхүүжилтийн гүйцэтгэлийн тооцооллыг сайтар нягталж, хянах (“сая төгрөг” гэж тооцсон тохиолдолд санхүүжилтийн дүнг саяар илэрхийлж, нэгжийг алдаагүй оруулах, цифр, оронгийн алдаа гаргахгүй байх);

4.Төслийн явц, үйл ажиллагаатай холбоотой хяналт-шалгалт, мониторинг хийсэн бол хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд мониторингийн тайланг хавсаргаж ирүүлэх;

5.Төлөвлөгөөнд үндсэн хариуцагчаар батлагдсан бол хамтран хариуцагч байгууллага тус бүрээс хэрэгжилтийн тайлан болон санхүүжилтийн гүйцэтгэлийг авч нэгтгэх, мэргэжлийн болон гадаад товчилсон үг хэллэгийг тайлбартайгаар ирүүлэхэд анхаарах;

6.Санхүүжилтийн гүйцэтгэлийн дүнг гадаад валютаар илэрхийлэх, сая төгрөгөөр илэрхийлэхээр заасан байхад тэрбум төгрөг, мянган төгрөгөөр оронгийн нарийвчлалгүй буруу тайлагнах, зарим төсөл, арга хэмжээний хувьд тухайн онд зарцуулсан хөрөнгийг өмнөх онуудад зарцуулсан хөрөнгөтэй хамт өссөн дүнгээр тайлагнах, эх үүсвэрийг дурдаагүй байх, үндсэн хариуцагчийн тайлагнасан санхүүжилтийн дүнд хамтран хариуцагчийн гүйцэтгэлийн дүн тусгагдсан эсэх нь тодорхойгүй зэрэг нийтлэг дутагдлыг залруулж, яамд, байгууллагууд хоорондын ажлын уялдааг сайжруулах;

7.Нийтлэг журмын 6.8-т “Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана.”, 10.4-т “Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргаж болно.” гэж заасан байхад хэрэгжилтийг 2,000 тэмдэгтэд багтааж тайлагнахгүйгээр тайланд тусгах боломжгүй мэдээллийг агуулсан материал хавсаргасан мөн хэрэгжилт дээр цахим холбоос байршуулсан байгааг залруулж, журмын хэрэгжилтийг хангах зэрэг болно.

----- оОо -----